



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/635

Номгон

Аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлох өрсөлдөх чадварын судалгааны ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 21 аймгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлох өрсөлдөх чадварын судалгаа, орон нутгийн бизнесийн орчны судалгаануудыг зохион байгуулахад шаардлагатай 750,000 (Долоон зуун тавин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Судалгаанд оролцох аж ахуй нэгжийг бүрэн хамруулж чанартай зохион байгуулж, судалгааны үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбар /Г.Энхтүвшин/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210483